

**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛД  
ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

2019.12.25

Улаанбаатар хот

№	Хэлэлцүүлэх асуудал	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс	Хариуцах албан хаагч	Хэрэгжилтийн байдал	Үнэлгээ (хувь)
1.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах	1 дүгээр сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Э.Солонго /Мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100
2.	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах	1 дүгээр сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Н.Буянт /Ахлах мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100
3.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах	1 дүгээр сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Н.Буянт /Ахлах мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100

4.	Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар	1 дүгээр сард	ТЗДТБХЗГ	Д.Жавхлан /Хэлтсийн дарга/ Д.Ганбаатар /ахлах мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн	100
5.	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн талаар	2 дугаар сард	АТБХЗХ, ИНЕГ /Ажлын хэсэг/	Д.Мягмарсүрэн /Хэлтсийн дарга/ Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/	Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр хуралдаанаар хэлэлцсэн. Уг хуулийн төслийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэний дагуу хуулийн төсөл дээр ажиллаж байна.	100
6.	“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концесс олгох тухай	2 дугаар сард	БТГ, АТБХЗХ ИНЕГ /Үндэсний хөгжлийн газар/	Р.Мэргэн /Газрын дарга/ Д.Мягмарсүрэн /Хэлтсийн дарга/ Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/ Д.Бямбасүрэн /Мэргэжилтэн/	“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хэлэлцээрийг дуусгаж нисэх буудлын үйл ажиллагааг 2019 оны 07 дугаар сарын 05-нд менежментийг эхлүүлэх ёслол болж, концессийн гэрээг байгуулсан. Сайдын зөвлөлийн хуралдаанаар оруулах шаардлаггүй болно.	100
7.	Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар	2 дугаар сард	ТЗДТБХЗГ	А.Батболд Газрын дарга Т.Мөнхцэцэг /Ахлах мэргэжилтэн/	Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100
8.	Автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийн талаар	2 дугаар сард	АТБХЗГ	Г.Гантулга /Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/ З.Чүнсэрээ /Мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанаар “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг. 2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017 стандартыг хэрэгжүүлэх эсэх талаар болон тээврийн хэрэгслийн улсын дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид, тэдгээрийн үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.	100

9.	Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32 км хурдны авто замын ашиглалтын бэлэн байдлыг хангуулах асуудлын талаар	3 дугаар сард	АЗБХЗГ	Х.Оргил-Эрдэнэ /Хэлтсийн дарга/ Д.Оюунбилэг /Ахлах мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 101 дүгээр тушаал тушаалаар шийдвэрлэсэн. Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон.	100
10.	Улаанбаатар-Дархан-Алтанбулаг, Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замын шинэчлэлийн ажлын явцын талаар танилцуулах	3 дугаар сард	АЗХБЗГ	Д.Доржханд /Газрын дарга/ Ч.Сугармаа /Мэргэжилтэн/	Улаанбаатар-Дархан-Алтанбулаг, Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замын шинэчлэлийн ажлын явцын талаар тухай бүр сайдын шуурхай хуралд мөн ЗТХСайдад танилцуулан ажиллаж байна. Улаанбаатар-Налайх чиглэлийн авто замын барилгын ажил 44%-ийн гүйцэтгэлтэй байна. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлыг 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр 5 багц хэсгээр эхлүүлсэн бөгөөд нийт ажлын гүйцэтгэл 28.4 хувьтай байна.	100
11.	Үндэсний хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тухай	3 дугаар сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Д.Баярмаа /Ахлах мэргэжилтэн/ О.Нямхүү /Ахлах мэргэжилтэн/ Б.Гантөмөр /Ахлах мэргэжилтэн/ Д.Ариунтуяа /Мэргэжилтэн/	Үндэсний хөтөлбөр, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100
12.	“Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын төслийн талаар	3 дугаар сард	АЗБХЗГ	Х.Оргил-Эрдэнэ /Хэлтсийн дарга/ Б.Дархандаръяа /Мэргэжилтэн/ Р.Буд /ЗТХТ ТӨҮГ-ын захирал/	“Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам”-ын төслийг Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзсэн. Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 07 өдрийн 312 тогтоолоор “Авто замын санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам” батлагдсан.	100

13.	Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах	3 дугаар сард	ХШУДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Д.Баярмаа /Ахлах мэргэжилтэн/ О.Нямхүү /Ахлах мэргэжилтэн/ Д.Ариунтуяа /Мэргэжилтэн/	Төрөөс баримтлах бодлогуудын хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн	100
14.	“Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын царигийн асуудлын талаар	3 дугаар сард	ТЗДТБХЗГ	А.Батболд /Газрын дарга/ Л.Булганхүү /Ахлах мэргэжилтэн/	Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогод нэмэлтээр оруулах УИХ-ын тогтоолын төсөл 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын 23 дугаар хуралдааны тэмдэглэлээр дэмжигдэж, Улсын Их Хурлын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 71 дүгээр тогтоолоор “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 280 км төмөр замыг нэмэлтээр тусгаж баталсан. Төмөр замын бодлогод Монгол Улсад шинээр барих төмөр зам нь одоо ашиглагдаж байгаа <b>төмөр</b> замын шугамтай шууд холбогдох буюу огтолцох нөхцөлд түүний царигийн өргөн нь 1520 мм байна гэж заасан тул Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагагүй болсон.	100
15.	Төрөөс авто замын талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийн тухай	4 дүгээр сард	АЗБХЗГ	Д.Доржханд /Газрын дарга/ Х.Оргил-Эрдэнэ /Хэлтсийн дарга/ Б.Оюундэлгэр /Ахлах мэргэжилтэн/ Д.Загдраднаа /Ахлах мэргэжилтэн/	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамд заасны дагуу бодлогын баримт бичгийн суурь судалгааны ажил зөвлөх үйлчилгээний хүрээнд боловсруулагдсан. Бодлогын баримт бичгийн төслийн 2 хувилбар боловсруулагдсан. 1. Дотоодын зөвлөх компанийн боловсруулсан бодлогын баримт бичгийн төслийн хувилбар; 2. АХБ-ны Техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулагдсан бодлогын баримт бичгийн төслийн хувилбараар боловсруулагдсан. Боловсруулагдсан хувилбар тус бүрийг АЗБХЗГ-аас олон нийтээр хэлэлцүүлж, санал авсан байна. Журамд заасан холбогдох дагалдах тооцоо, судалгааны төсөл боловсруулагдсан.	70

					Гэвч Монгол улсын Засгийн газраас “Монгол Улсыг урт хугацаанд хөгжүүлэх бодлого 2020-2045 он”-ыг боловсруулах шийдвэрийг гаргасан бөгөөд урт хугацааны бодлогын зорилго, зорилтыг боловсруулахдаа салбар хоорондын бодлогын уялдааг сайтар хангах зарчмын хүрээнд Төрийн нарийн бичгийн даргаас салбарын төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг түр хойшлуулах чиглэл өгч тус ажлыг түр хойшлуулсан	
16.	“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр” батлуулах тухай	4 дүгээр сард	АТБХЗХ ИНЕГ	Д.Мягмарсүрэн /Хэлтсийн дарга/ Л.Бямбасүрэн /ИНЕГ-ын дарга/	“Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. Мөн Засгийн газрын 2019.07.03-ны өдрийн 283 дугаар тогтоолоор “Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр”-ийг батлуулсан.	100
17.	Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хөдөлгөөний аюулгүй байдлын талаар	5 дугаар сард	АТБХЗГ	Г.Гантулга /Газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч/ А.Энхболд /Мэргэжилтэн/	Уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хөдөлгөөний аюулгүй байдлын талаар Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх материалыг бэлтгэн 2019.12.13-ны өдөр Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлсэн.	70
18.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах	6 дугаар сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Л.Шинэчимэг /Мэргэжилтэн/	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр Зам, тээврийн хөгжлийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Зам, тээврийн хөгжлийн дэд Сайдын 2019 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн 01/3554 дугаартай албан тоотой Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	100
19.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх	6 дугаар сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Н.Буянт /Ахлах мэргэжилтэн/	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр туссан зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд	100

	арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах.				2019 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Зам, тээврийн хөгжлийн дэд Сайдын 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 02/3433 дугаартай албан тоотоор Сангийн Сайд Ч.Хүрэлбаатарт хүргүүлсэн, мөн <a href="http://www.unelgee.mn">www.unelgee.mn</a> сайтад байршуулсан.	
20.	Зам, тээврийн хөгжлийн яамны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар 2019 оны хагас жилийн байдлаар танилцуулах	6 дугаар сард	ТЗУГ	Ш.Мөнхбулган /Мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн яаманд 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар иргэдээс нийт 207 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс шийдвэрлэж хариу өгсөн 184, хуулийн хугацаа нь болоогүй шийдвэрлэхээр судлан хяналтад байгаа 23 өргөдөл байна. Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Зам, тээврийн хөгжлийн яамны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг 2019 оны жилийн эцэст сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн болно.	100
21.	“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг танилцуулах	8 дугаар сард	ХШҮДАГ	М.Энхболд /Газрын дарга/ Н.Буянт /Ахлах мэргэжилтэн/	“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д зам, тээврийн салбарын хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний биелэлтийг нэгтгэн дүгнэж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн. Тайланг Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 30 дугаар тэмдэглэлийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн 01/4616 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	100
22.	Зам, тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын багцын 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн төслийн саналыг хэлэлцүүлэх	8 дугаар сард	БТГ	Р.Мэргэн /Газрын дарга/ Ч.Ренчиндамба /Хэлтсийн дарга/ Ш.Гүнсэндарь /Ахлах мэргэжилтэн/ З.Цэрэнгомбо /Мэргэжилтэн/	Монгол Улсын 2020 оны Төсвийн хязгаар батлагдаж ирсэнтэй холбоотойгоор Зам тээврийн хөгжлийн сайд /ТЕЗ/-ын 2020 оны төсвийн багцад өгсөн харьяа байгууллага, газруудаас ирсэн саналыг нэгтгэж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн.	100

					Тус саналыг 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/4326 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	
23.	Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрт нэвтрүүлэх, тооцоо, судалгааны талаар	8 дугаар сард	ТЗДТБХЗГ	А.Батболд /Газрын дарга/ Б.Батнасан /Мэргэжилтэн/ Г.Даваадолгор /Мэргэжилтэн/	Сайдын 2018 оны 248 дугаар тушаалаар байгуулагдсан Монгол Улсын нутгаар давхар чингэлгэн ачилттай хөдлөх бүрэлдэхүүн аялуулах боломж, техникийн нөхцөлийн талаар судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсэг холбогдох судалгааг хийж, судалгаанд тулгуурлан туршилтын давхар ачилгат чингэлгийн овортой жаазтай вагоныг Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөөнөөс Толгойт өртөө хооронд амжилттай аялуулсан бөгөөд Ажлын хэсгээс БНХАУ-ын Цицихар хотын үйлдвэр дээр очиж, Монгол улсад С70 загварын вагон үйлдвэрлэх асуудал болон давхар ачилгат чингэлгийн вагоны техникийн нөхцөлийн болон бусад нэмэлт судалгаа хийх дүгнэлт гаргаад байна. Ажлын хэсэг 2020 онд БНХАУ-ын “China CRRC” корпорацитай туршлага судлах уулзалтыг зохион байгуулж, нэмэлт судалгаа хийх шаардлагатай байгаа тул “Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрлэлтэд нэвтрүүлэх” асуудлыг ирэх жилийн Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөнд тусгуулахаар ТЗУГ-т хүсэлтээ хүргүүлээд байна.	70
24.	“Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ын шинэчилсэн найруулгын төслийн талаар	8 дугаар сард	ТЗДТБХЗГ	А.Батболд /Газрын дарга/ Д.Жавхлан /Хэлтсийн дарга/ Д.Ганбаатар /Ахлах мэргэжилтэн/	Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл УИХ-д хэлэлцэгдэж байгаа бөгөөд “Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн журам”-ын төслүүдийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөл батлагдсаны дараа журмын төслүүдийг батлуулахаар түр хүлээгдэж байна.	70
25.	Зам, тээврийн салбарын стратеги төлөвлөгөөний төслийн талаар	9 дүгээр сар	БТГ	Р.Мэргэн /Газрын дарга/ Ж.Сэрээтэр /Хэлтсийн дарга/ С.Эрдэнэсайхан /Мэргэжилтэн/	ЗТХЯ-ны ТНБД-ын 2019.10.23-ны өдрийн 323 дугаар тушаалаар “Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагааны стратеги”-ийг баталсан.	100

26.	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийн талаарх судалгааны талаар	9 дүгээр сард	ТЗДТБХЗГ	А.Батболд /Газрын дарга/ Т.Мөнхцэцэг /Ахлах мэргэжилтэн/	Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний хөдөлгөөнийг хянах технологийн нэвтрүүлэхээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.04.30-ны өдрийн 129 дүгээр тушаалаар байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу судалгаа хийж төслийг эцэслэн боловсруулсан. Энэхүү төслийг Сайдын дэргэд дэх Шинжлэх ухаан технологийн Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр тус төсөл болон холбогдох материалуудыг 2019 оны 11 сарын 06-ны өдрийн дотоод албан бичгээр БТГ-ын Ахлах мэргэжилтэн Д.Гэрэлнямд хүргүүлэв. Энэ асуудлыг ирэх жилийн Сайдын зөвлөлийн хуралдааны төлөвлөгөөнд тусгуулахаар ТЗУГ-г хүсэлтээ хүргүүлээд байна.	70
27.	Зам, тээврийн хөгжлийн яамны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн талаар 2019 оны жилийн эцсийн байдлаар танилцуулах	12 дугаар сард	ТЗУГ	Ш.Мөнхбулган /Мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн яаманд 2019 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нийт 401 өргөдөл, гомдол, хүсэлт ирснээс шийдвэрлэж хариу өгсөн 394, хуулийн хугацаа нь болоогүй шийдвэрлэхээр судлан хяналтад байгаа 7 өргөдөл байна. Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 98.2%-тай байна. Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй байна. Зам, тээврийн хөгжлийн яамны өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн танилцуулга, тайланг яамны удирдлагуудад танилцуулсан.	100

### БУСАД АСУУДЛУУД

№	Хэлэлцүүлэх асуудал	Хугацаа	Хариуцах газар, хэлтэс	Хариуцах албан хаагч	Биелэлт	Үнэлгээ (хувь)
28.	Зам, тээврийн яам /хуучнаар/ болон “Ви Эйч Энд Би” ХХК, “Есүй ордон” ХХК-ийн түншлэл хооронд байгуулсан “Ачаа, шуудан тээврийн үйлчилгээний барилга”, “Захиргааны барилга”, “Нисэх буудлын үйлчилгээний барилга”-ын ажил гүйцэтгэх гэрээний хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар	03 сард	ХШҮДАГ, ИНЕГ	М.Энхболд /Газрын дарга/ Д.Бямбасүрэн	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019.03.07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100



29.	Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 60 дугаар тушаалаар томилогдсон Ажлын хэсгийн “МИАТ” ТӨХК, “Изинис Эйрвэйз” ХХК хооронд 2019 онд байгуулсан 19/013, 19/17 тоот гэрээний талаар гаргасан дүгнэлтийн талаар	02 дугаар сард	БТГ, ХШҮДАГ	Р.Мэргэн /Газрын дарга/ Д.Баярмаа /Ахлах мэргэжилтэн/	Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн 2019.02.28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн.	100
-----	--	----------------	-------------	---	--	-----

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**  
 АВТО ЗАМЫН САЛБАРЫН БОДЛОГО, ХӨТӨЛБӨР,  
 ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
 АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ГАНТӨМӨР